

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
2007 оны 08 дугаар сарын 03-ны өдөр
Улаанбаатар хот

**ХОХИРЛЫГ ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛӨӨР
БАРАГДУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулиар хадгаламж зээлийн зарим хоршооны үүсгэн байгуулагчдын буруутай үйл ажиллагааны улмаас хадгаламж эзэмшигчдэд учирсан хохирлын тодорхой хэсгийг төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль тогтоомж

2.1.Хохирлыг эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Иргэний хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь хууль хүчин төгөлдөр болохоос өмнө эрүүгийн хэрэг үүсгэж, шүүхийн шийтгэх тогтоолоор хохирлынх нь бодит хэмжээг тогтоосон хадгаламж зээлийн хоршооны хохирогчдод хамаарна.

3.2.Энэ хуулийн 3.1-д заасан бодит хохиролд хадгаламжийн хүү үл тооцно.

4 дүгээр зүйл. Хохирол барагдуулах хэмжээ

4.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлд зааснаар тогтоогдсон хохирлын 50 хувийг төрөөс эргэн төлөгдөх нөхцөлөөр барагдуулна.

5 дугаар зүйл. Хохирол барагдуулах эх үүсвэр, түүнийг нөхөн бүрдүүлэх

5.1.Энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан хохирлыг улсын төсвийн хөрөнгөөр барагдуулна.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасны дагуу улсын төсвийн хөрөнгөөс барагдуулсан хохирлыг тухайн хоршооны дараахь орлого, мөнгөн хөрөнгөөс түүнд оногдох хэмжээгээр нь нөхөн төлүүлнэ:

5.2.1.төлбөр төлөгчөөс гаргуулан авсан бэлэн мөнгө;

5.2.2.харилцах дансан дахь төгрөг, гадаад валют;

5.2.3.төлбөр төлөгчөөс хураан авсан хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлого;

5.2.4.үнэт цаас борлуулсны орлого;

5.2.5.газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг худалдан борлуулснаас олсон орлого;

5.2.6.ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу худалдан борлуулснаас олсон орлого;

5.2.7.хоршооны үйл ажиллагааны орлого;

5.2.8.бусад орлого.

5.3.Энэ хуулийн 5.2-т заасан орлого, мөнгөн хөрөнгийг эхний ээлжинд улсын төсөвт шилжүүлэх бөгөөд уг ажиллагаа энэ хуулийн 4.1-д заасан төлбөрийг улсын төсөвт буцаан төлж дуусгах хүртэлх хугацаанд үргэлжилнэ.

5.4.Энэ хуулийн 5.3-т заасан орлого, мөнгөн хөрөнгө хуваарилах ажиллагаа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 49.3, 70.1 дэх хэсэгт хамаарахгүй.

6 дугаар зүйл. Хохирол барагдуулах журам

6.1.Хохирол барагдуулах журмыг Засгийн газар батална.

7 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

7.1.Энэ хуулийг 2007 оны 8 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН